ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Зүүнбаян Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ӨВА-2022/68/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Өвөрхангай аймаг<br>Арвайхээр сум<br>2022 он | Өвөрхангай аймгийн Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: О.Батжаргал<br>Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Гансүх<br>Утас: 99328832 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com<br><br>Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг<br>Утас: 70323108 Цахим хаяг:<br><br>Аудитор: Д.Дашзэвэг<br>Утас: 95329926 Цахим хаяг: dashzeveg_d@yahoo.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт....... **Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....... 2
3. Аудитын тайлан ....... 9
   3.1 Ерөнхий зүйл ....... 9
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....... 9
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....... 9
   3.4 Материаллаг байдал....... 10
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....... 10
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....... 10
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....... 11
   3.8 Аудитын гол асуудал....... 11
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....... 11
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....... 12
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....... 12
4. Аудитын илрүүлэлт....... 12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....... 12

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 288.

танай ____________-ны №____________-т

ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН ЕБС-ИЙН
ЗАХИРАЛ Н.ОДОНЧИМЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнбаян Улаан сумын ЕБСургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зүүнбаян Улаан ЕБСургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

015030576

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | **41383521.84** | **35803360.88** |
| **33** | **АВЛАГА** | 8600006.27 | 81934.94 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 6.27 | 81933.94 |
| **335** | **Бусад авлага** | 8600000.00 | |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 8600000.00 | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 32783515.57 | 35721426.94 |
| **351** | **Түүхий эд материал** | 19864115.57 | 14897336.94 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 19864115.57 | 14897336.94 |
| **354** | **Хангамжийн материал** | 12919400.00 | 20824090.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 187700.00 | 70000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5128300.00 | 12131180.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2796500.00 | 1553000.00 |
| 35460 | Хүнсний материал | 4806900.00 | 3882310.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 0.00 | 3187600.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | **1523306689.93** | **1492464481.24** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1523306689.93 | 1492464481.24 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1466327856.45 | 1435526481.24 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1448383524.62 | 1448383524.62 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -88174103.92 | -137277045.40 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 19625000.00 | 19625000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -1090277.76 | -4361111.04 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 92405256.47 | 69855637.14 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -74453603.15 | -28482105.06 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 113720628.34 | 110880730.34 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -70405503.41 | -77414318.27 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 76692435.63 | 88021228.83 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -67935584.50 | -72800096.37 |
| 39217 | Ном | 17560084.13 | 19095036.45 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 56978833.48 | 56938000.00 |
| 39301 | Програм хангамж | 490000.00 | 490000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -449166.52 | -490000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 56938000.00 | 56938000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | **1564690211.77** | **1528267842.12** |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | **1564690211.77** | **1528267842.12** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1564690211.77 | 1528267842.12 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 653261490.00 | 653261490.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 653261490.00 | 653261490.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 153247857.83 | 116825488.18 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 153247857.83 | 153247857.83 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | -36422369.65 |

| | | | |
|---|---|---|---|
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 758180863.94 | 758180863.94 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** VI=IV+V | **1564690211.77** | **1528267842.12** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **859288417.57** | **871084246.03** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **41379617.57** | **49030861.03** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 41379617.57 | 49030861.03 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 41379617.57 | 49030861.03 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 41379617.57 | 49030861.03 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **817908800.00** | **822053385.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 651973000.00 | 672952100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 651973000.00 | 672952100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 10540000.00 | 1112785.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10540000.00 | 1112785.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 155395800.00 | 147988500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 155395800.00 | 147988500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **905362274.19** | **907506615.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **905362274.19** | **907506615.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 811945761.60 | 851730881.80 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 505894909.00 | 497606740.73 |
| 210101 | Үндсэн цалин | 344676943.00 | 497606740.73 |
| 210102 | Нэмэгдэл | 123752746.00 | |
| 210104 | Урамшуулал | 37465220.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 63796781.14 | 65701926.72 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43959374.32 | 47397641.10 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4991657.03 | 4711189.55 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3973166.42 | 3705111.66 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 988844.52 | 898907.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9883738.85 | 8989076.74 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 121253909.00 | 141201941.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3648909.00 | 3502141.00 |
| 210302 | Түлш, халаалт | 117437000.00 | 137204800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 168000.00 | 495000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5733890.00 | 4305471.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 426200.00 | 791371.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1418000.00 | 1418000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 150000.00 | 225000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1965680.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1774010.00 | 1871100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 21450420.00 | 50054904.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 261400.00 | 1195014.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21092520.00 | 47760990.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 96500.00 | 1098900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7832800.00 | 4534100.00 |
| 210604 | Урсгал засвар | 7832800.00 | 4534100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 42000.00 | 336000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 42000.00 | 336000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2583410.00 | 1609130.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2007410.00 | 1609130.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 83357642.46 | 86380668.35 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 132000.00 | 345000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 680700.00 | 7359100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 82544942.46 | 78676568.35 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 93416512.59 | 55775733.88 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10941250.00 | 27635200.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 10052250.00 | 26735200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 889000.00 | 900000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 82475262.59 | 28140533.88 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 82475262.59 | 28140533.88 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-46073856.62** | **-36422373.65** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 653,261,490.00 | 758,180,863.94 | 153,247,857.83 | 1,564,690,211.77 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **653,261,490.00** | **758,180,863.94** | **153,247,857.83** | **1,564,690,211.77** |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **653,261,490.00** | **758,180,863.94** | **153,247,857.83** | **1,564,690,211.77** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **653,261,490.00** | **758,180,863.94** | **153,247,857.83** | **1,564,690,211.77** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **653,261,490.00** | **758,180,863.94** | **153,247,857.83** | **1,564,690,211.77** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -36,422,369.65 | -36,422,369.65 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **653,261,490.00** | **758,180,863.94** | **116,825,488.18** | **1,528,267,842.12** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | **821190600.00** | **825864385.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3281800.00** | **3811000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3281800.00 | 3811000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 3281800.00 | 3811000.00 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 3281800.00 | 3811000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | **817908800.00** | **822053385.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 651973000.00 | 672952100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 651973000.00 | 672952100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 10540000.00 | 1112785.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,540,000.00 | 1,112,785.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 155395800.00 | 147988500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 155395800.00 | 147988500.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | **819250600.00** | **823329385.00** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | **819250600.00** | **823329385.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **725834087.41** | **764366051.12** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 505890456.00 | 497571894.25 |
| 210101 | Үндсэн цалин | 344672690.00 | 363778941.27 |
| 210102 | Нэмэгдэл | 123752546.00 | 105537541.39 |
| 210104 | Урамшуулал | 37465220.00 | 28255411.59 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 63789462.41 | 65818700.87 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43952056.24 | 45967985.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4991657.03 | 5104830.68 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3973166.42 | 4016664.58 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 988844.52 | 975383.62 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9883738.20 | 9753836.44 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 120548309.00 | 141201941.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3648909.00 | 3502141.00 |
| 210302 | Түлш, халаалт | 116731400.00 | 137204800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 168000.00 | 495000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5122680.00 | 4391571.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 468900.00 | 673671.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1418000.00 | 1418000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 150000.00 | 225000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 60000.00 | 424900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1965680.00 | 305900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1060100.00 | 1344100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 13599370.00 | 48412114.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 261400.00 | 889114.00 |
| 210502 | Хоол, хүнс | 12652270.00 | 46836400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 685700.00 | 686600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12361400.00 | 2910000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8600000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 3761400.00 | 2910000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 42000.00 | 336000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 42000.00 | 336000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2583410.00 | 1609130.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2007410.00 | 1609130.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1897000.00 | 2114700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 132000.00 | 345000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1765000.00 | 1769700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **93416512.59** | **58963333.88** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10941250.00 | 30822800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 10052250.00 | 29922800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 889000.00 | 900000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 82475262.59 | 28140533.88 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 82475262.59 | 28140533.88 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1940000.00** | **2535000.00** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1940000.00** | **2535000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1940000.00** | **2535000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1940000.00 | 2535000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1940000.00 | 2535000.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-1940000.00** | **-2535000.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны төлөвлөгөө | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны төлөвлөгөө | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 818289100.00 | 724893537.41 | 820940601.00 | 792800567.12 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 818289100.00 | 724893537.41 | 820940601.00 | 792800567.12 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 803718700.00 | 713952287.41 | 790117801.00 | 761977767.12 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 531786000.00 | 505890456.00 | 520561200.00 | 497571894.25 |
| 210101 | Үндсэн цалин | 347553300.00 | 344672690.00 | 375273900.00 | 363778941.27 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 140488100.00 | 123752546.00 | 116837500.00 | 105537541.39 |
| 210104 | Урамшуулал | 43744600.00 | 37465220.00 | 28449800.00 | 28255411.59 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 76246200.00 | 63789462.41 | 66678300.00 | 65818700.87 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53654700.00 | 43952056.24 | 48977200.00 | 45967985.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5647900.00 | 4991657.03 | 4425300.00 | 5104830.68 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4518300.00 | 3973166.42 | 3540200.00 | 4016664.58 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1129600.00 | 988844.52 | 885100.00 | 975383.62 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11295700.00 | 9883738.20 | 8850500.00 | 9753836.44 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 151634800.00 | 120548309.00 | 145078500.00 | 141201941.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7839100.00 | 3648909.00 | 6603900.00 | 3502141.00 |
| 210302 | Түлш, халаалт | 141455700.00 | 116731400.00 | 137204800.00 | 137204800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2340000.00 | 168000.00 | 1269800.00 | 495000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4065600.00 | 3462100.00 | 4071700.00 | 3905900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 468900.00 | 468900.00 | 470200.00 | 470200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1418000.00 | 1418000.00 | 1418000.00 | 1418000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 389800.00 | 150000.00 | 390800.00 | 225000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 423700.00 | 60000.00 | 424900.00 | 424900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 305100.00 | 305100.00 | 305900.00 | 305900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1060100.00 | 1060100.00 | 1061900.00 | 1061900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 32623900.00 | 13599370.00 | 47785000.00 | 47785000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 261400.00 | 261400.00 | 262000.00 | 262000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 31676800.00 | 12652270.00 | 46836400.00 | 46836400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 685700.00 | 685700.00 | 686600.00 | 686600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3761400.00 | 3761400.00 | 2910000.00 | 2910000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3761400.00 | 3761400.00 | 2910000.00 | 2910000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 502800.00 | 42000.00 | 504200.00 | 336000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 502800.00 | 42000.00 | 504200.00 | 336000.00 |
| **2108** | **Бусдаар** | 988400.00 | 962190.00 | 413601.00 | 333631.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | | | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 412400.00 | 386190.00 | 413600.00 | 333630.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576000.00 | 576000.00 | 1.00 | 1.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2109600.00 | 1897000.00 | 2115300.00 | 2114700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 344600.00 | 132000.00 | 345600.00 | 345000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1765000.00 | 1765000.00 | 1769700.00 | 1769700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 14570400.00 | 10941250.00 | 30822800.00 | 30822800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14570400.00 | 10941250.00 | 30822800.00 | 30822800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 13670400.0 | 10052250.0 | 29922800.00 | 29922800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 900000.00 | 889000.00 | 900000.00 | 900000.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **2388285.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **2388285.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 2388285.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 485671.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 203,471.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 282,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 0.00 | 627114.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 627,114.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.00 | 1275500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 1,275,500.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 1112785.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 1112785.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн | - | 1,112,785.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | захирагчид хуваарилсан хөрөнгө | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Зүүнбаян Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд холбоотой өгсөн албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг Дөлгөөнхайрхан Уул Аудит ХХК-ийн аудитор Д.Дашзэвэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д. Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнбаян Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дөлгөөнхайрхан Уул Аудит ХХК-д 2022 оны 02 дугээр сарын 08-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

**Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл:**

Зүүнбаян Улаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1."Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино" гэж заасан зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж ирсэн.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнбаян Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн зарлагын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлага 905,3 сая төгрөгөөс 1,5 хувиар буюу 13,6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Тайлант онд 1825814,9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэлтэй байсан бол 2535,0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 8600,0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, 22743,7 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй орлогоор бүртгэн дахин үнэлгээгээр 13955,6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, 5302,0 мянган төгрөгийн хөрөнгө акталж, дахин үнэлгээний хорогдлоор 55058,0 мянган төгрөгөөр тус тус хасагдаж 1813289,2 мянган төгрөгийн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын хувьд 32783,5 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан бол тайлант онд 97038,9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 94101,0 мянган төгрөг зарцуулж 35721,4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Авлага 8600,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 81,9 мянган төгрөг болж 8518,1 мянган төгрөгөөр буурсан байна.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Орон нутгийн төсвөөс тогтмол зардалд 147988,5 мянган төгрөг, Улсын төсвөөс биеийн тамир уралдаан тэмцээний зардалд 345,6 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг 900,0 мянган төгрөг, үдийн цай хөтөлбөрт 29922,8 мянган төгрөг, дотуур байрны үйлчилгээ 46836,0 мянган төгрөг, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд 593529,3 мянган төгрөг, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардалд 1418,0 мянган төгрөг, нийт 820940,6 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр тогтмол зардалд 144111,9 мянган төгрөг, биеийн тамир уралдаан тэмцээний зардалд 345,6 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг 900,0 мянган төгрөг, үдийн цай хөтөлбөрт 29922,8 мянган төгрөг, дотуур байрны үйлчилгээ 46836,4 мянган төгрөг, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд 593529,3 мянган төгрөг, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардалд 1418,0 мянган төгрөг, нийт 792801,1 мянган төгрөгийг зарцуулж, 28139,5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 1112,7 мянган төгрөгийн санхүүжилт авсан.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсгийн талаар тодруулах мэдээлэл байхгүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.
Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэсэн.
Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд оруулах ёстой мэдээллийг бүрэн оруулсан.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд аудитын түүвэрт хамрагдсан.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсвийн хөрөнгийн зарцуулалтад анхаарах .

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 2,5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### 4.3 Албан шаардлага

1. Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын хэрэгжилтийг шалгахад: тайлант хугацаанд ажлын дүрэмт хувцас авахад 0,4 сая төгрөг зарцуулсан нь мөн тогтоолын 1,4-д ажлын дүрэмт хувцас худалдан авахгүй байх, албан томилолтод 0,3 сая төгрөг зарцуулсан нь тогтоолын 1,5-д хурал зөвлөгөөн, газар дээрх хяналт шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж дотоод албан томилолтын зардлыг хэмнэх, тайлант хугацаанд спортын уралдаан тэмцээнд 0,3 сая төгрөгийг зарцуулсан нь тогтоолын 1,6-д спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2. Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын нормативыгг 0,7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан , мөн 1-6-р ангийн сурагчдын үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 1-6 сард 1,2 сая төгрөгөөр хэтрүүлсэн ба 2021 оны 9-12 сард 0,4 сая төгрөгөөр хэмнэсэн ба нийт дүнгээрээ 0,8 сая төгрөгөөр хэтрүүлсэн зарцуулсан зэрэг нь МУЗГ-ын 2019 оны 12 сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолоор батлагдсан зардлын нормативыг хэтрүүлсэн байна.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Зүүнбаян Улаан сумын ЕБС | 3 | 2,5 | | | | | 2 | 2,5 | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР Д.ДАШЗЭВЭГ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 23-НИЙ ӨДӨР

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр Дугаар 08А-2022/1НА-СТА-ТШЗ/19425219/193 Арвайхээр

Зүүнбаян улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Н.Одончимэг танаа

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд ажлын дүрэмт хувцас авахад 0.4 сая төгрөг, албан томилолтод 0.3 сая төгрөг, спортын уралдаан тэмцээнд 0.3 сая төгрөг, нийтдээ 1.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2."батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;", 16.5.5.-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.4-д “ажлын дүрэмт хувцас худалдан авахгүй байх”, 1.5-д “хурал зөвлөгөөн, газар дээрх хяналт шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж дотоод албан томилолтын зардлыг хэмнэх”, 1.6-д “спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан “хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээрх дурдсан Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1-ийн 4-6 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зүүнбаян Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Н.Одончимэг, нягтлан бодогч Л.Лхам нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТОР Д.ДАШЗЭВЭГ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр Дугаар 08А-2022/ / НА-СТА-ЗУБ/19425219/191 Арвайхээр

Зүүнбаян улаан сумын Ерөнхий боловсролын
сургуулийн захирал Н. Одончимэг танаа

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын нормативыг 0,7 сая төгрөгөөр, 1-6-р ангийн сурагчдын үдийн хоолны зардлын нормативыг 0,8 сая төгрөгөөр хэтрүүлсэн зарцуулсан

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, МУЗГ-ын 2019 оны 12 сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолоор батлагдсан зардлын нормативтай нийцэхгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан “хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээрх дурдсан Засгийн газрын МУЗГ-ын 2019 оны 12 сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолоор батлагдсан зардлын нормативыг хэтрүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зүүнбаян Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Н.Одончимэг, нягтлан бодогч Л.Лхам нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТОР Д.ДАШЗЭВЭГ